



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 8/12

Цагаан-Овоо

Г Дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг Г  
байгуулах тухай


Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. Засгийн газрын 2011 оны "Нийтлэг журам батлах тухай" 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын дотоод хяналт шалгалтын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ахлагч:	Засаг даргын орлогч
Гишүүн:	Сангууд хариуцсан нягтлан бодогч
	Нэгдүгээр багийн Засаг дарга
	Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Архив, бичиг хэргийн ажилтан

2. Байгууллагын дотоод хяналт шалгалт зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гарган батлуулж, хэрэгжилтийг тайлагнан ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ГАНЧИМЭГ

ТАМГЫН ДАРГА БАТЛАВ Б.ГАНЧИМЭГ



ДОТООД ХЯНАЛТЫН НЭГЖИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны 09 дүгээр сарын 28

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Хугацаа	Хариуцах эзэн
<b>Нэг. ЗДТГ-ын үйл ажиллагааны хүрээнд</b>				
1.	ЗДТГ-ын ажилчдын цаг ашиглалтад хяналт тавьж ажлын хариуцлагыг сайжруулах	Ажлын хариуцлага нэмэгдэж бүтээмж сайжирсан байна.	Сар бүр	Нэгжийн гишүүд
2.	ТАХ-ын нарын эд хөрөнгө бүртгэл, ашиглалт хамгаалтад хяналт тавих	Эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт сайжирч хариуцах эзэнтэй болно	6,12 сард	Нэгжийн гишүүд
3.	Нэг цэгийн үйлчилгээний чанар хүртээмжид хяналт тавих	Нэг цэгийн үйлчилгээний чанар сайжирч иргэдэд нээлттэй үйлчилнэ.	8,11 сар	Нэгжийн гишүүд
4.	Багийн Засаг дарга нарын үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэх	Багийг Засаг дарга нарын үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнэн ажлын бүтээмжийг сайжруулна.	6,12 сар	Нэгжийн гишүүд
5.	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт хангалтыг баримталж зөвлөн туслах	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллах, ТАХ баримт бичгийн бүрдэл, эмх цэгц сайжирна.	11-12 сар	Нэгжийн гишүүд
<b>Хоёр: Хууль тогтоомжийн хүрээнд</b>				
1.	Шинэчилсэн хуулиудын найруулгаар сургалт зохион байгуулах	ТАХ-дын хуулийн мэдлэг сайжирч иргэдийг мэдээллээр хангана	Тухай бүр	Нэгжийн гишүүд
2.	Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн хэрэгжилт	Хуулийн хүрээнд үйл ажиллагаа явагдаж иргэдийг мэдээллээр хангасан байна.	10-11 сар	Нэгжийн гишүүд
<b>Бусад:</b>				
1.	Автомат худгийн бүрэн бүтэн байдал, цэвэрлэгээ, үйлчилгээнд хяналт хийх	Ундны усны эх үүсвэрт тухай бүр хяналтыг хийж худгийн бүрэн бүтэн байдлыг тогтмол хангаж ажиллана.	Сар бүр	Нэгжийн гишүүд
2.	Усны дээжийг шинжилгээнд хамруулсан эсэх	Усны дээжийг шинжилгээнд хамруулж ундны усны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.	9 сар	Нэгжийн гишүүд

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД